

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ
ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 05 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаалагч сүүлийн жилүүдэд дэлхийн нийтийг хамарсан цар тахал, геополитикийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан төгрөгийн ханш суларч, инфляц, зээлийн хүүгийн түвшин нэмэгдсэнтэй холбоотойгоор аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийг дэмжих, мөн бичил, жижиг бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжийг бүрдүүлэхтэй холбоотойгоор нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн босгыг 400.0 сая төгрөг болгон нэмэгдүүлэх, татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшинг харгалзан дотоодын болон импортын нэмэгдсэн өртгийн албан татварын төлбөрийг хоёр хүртэлх сарын хугацаагаар хойшлуулахаар хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар бизнес эрхлэгчдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн ачааллыг бууруулж бизнесээ идэвхжүүлэх, өргөжүүлэх боломжийг нэмэгдүүлж, нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ гэж үзсэн байна.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Татварын ерөнхий хуульд татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь хэмжээ болон татварын суурийг бууруулахтай холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулахаар тусгасан нь Засгийн газраас өргөн мэдүүлсэн татварын хуулиудтай хэрхэн уялдаж байгаа талаар, мөн нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчийн босгыг нэмэгдүүлсэнтэй холбоотой Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим болон аж ахуй нэгж байгууллагуудаас ирүүлсэн саналуудын талаар, Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн босгыг 400.0 сая төгрөг болгон нэмэгдүүлэхдээ хувь хүн, хуулийн этгээдэд ялгаатай бодлого баримтлах эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 68,8 хувийн саналаар, хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай

хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 68,8 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Н.НАРАНБААТАР